

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Су.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Батцогт, Б.Чойжилсүрэн нар Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байна.

2003 онд шинээр “далай аварга” цол бий болгосон нь Монгол үндэсний бөхийн хөгжил, өрсөлдөөн өндөр төвшинд хүрч буй одоо үед уламжлалт даян аварга, дархан аварга цолонд хүрэх боломжийг хязгаарлаж байгааг үндэслэн хууль санаачлагчид шинээр бий болсон “далай аварга” цолыг хасахаар уг хуулийн төслийг боловсруулжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэв.


Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА -Г**



А.БАКЕЙ